



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар A/76

Өмнөдэлгэр сум

**Мал, амьтны сэг зэм устгах,
орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 51.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/157 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны сэг зэмээс хүн, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумын нутаг дэвсгэрт зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэм устгах газрыг хавсралтаар баталсугай.

3. Бэлчээр, нийтийн эзэмшлийн зам, талбай, булаг шандны эргэн тойронд зүй бусаар үхэж хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулан зөвшөөрсөн цэгт төвлөрүүлж, холбогдох журмын дагуу устгахыг мал эмнэлгийн тасаг, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар, малчдад даалгасугай.

4. Устгалын цэгийг халдваргүйтгэх ажлыг шат дараатай зохион байгуулахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хариуцуулсугай.

5. Захирамжийн хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

D:disk/bichig hereg/ zahiramj/

2325310154

сумын Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн
А/36 дугаар захирамжийн хавсралт



Мал, амьтны сэг зэм устгах газрын байршил

№	Сэг зэм устгах газрын нэр	Баг	Газрын координат	
1	Баруун сайхан	Талын булаг	47°48'25.70"N	110°17'30.95"E
2	Доод хөтөл	Хэнтий	48°05'47.95"N	109°50'11.59"E
3	Айрагийн ухаа	Төв	47°53'51.94"N	109°50'45.27"E
4	Болдог	Гурванбаян	48°10'05.8"N	110°19'08.4"E